



МЭНДЧИЛГЭЭ

Айл гэрийн өмөг түшиг азай буурлууд, хүндэт ахмадууд, иргэд, хөдөлмөрчид өө Өвөг дээдэс, өндөр настнаа хүндлэн жаргаасан нутгийн ахан дүүс, зон олон минь ээ

XVII дугаар жарны ХҮСЛИЙН ТЭНГЭР хэмээгч хөхөгчин хонин жилийн сар ишний мэндийг Та бүхэндээ өргөн дэвшүүлж айл, гэр бүхэнд аз жаргал, хүн бүхэнд юу санасан есөн цагаан хүсэл нь сэтгэлчлэн бүтээж, эв зөтэй, энх жаргахын ашдын ерөөлийг өлзий болгон өргөн айлтгая.

Цагийн хатуу, цасны хайрууг ажралгүй давсан малчид, ард иргэд маань эцэг өвгөдийн үеэс хадгалан хөгжүүлж ирсэн уламжлалт их баяр



- Цагаан сараараа айл саахалт, ахан дүүс, халуун ам бүлээрээ хурин цуглаад нас нэмж, буян хурсан ихэс, дээдэстээ хүндэтгэл үзүүлж, уран цэцэн үеийг уралдуулан, мэнд амраа мэдэлцэж, уужуу саруул ухаанаар өнгөрсөн үйлийг дүгнэн хэлэлцэж, угтан золгож буй хөхөгчин хонин жилийн өнгө байдлыг шинэжин хөөрөлдөж, хотол олон, энх амгалан, эрүүл энх байхын билэгтэй үгээр биесээ хөхүүлэн мялаадаг эртний сайхан зан үйлээ бид уламжлал болгон өргөн дэлгэр тэмдэглэх гэж байна.

"Санаа сайн бол заяа сайн" гэдэг. Шинэ оноо санаа сайтай угтацгая

Эрхэм хүндэт иргэд ээ, угтан золгож буй хөхөгчин хонин жилдээ ард олон, айл хотлоороо аз жаргалтай, эрүүл энх, ажил үйлс нь өөдрөг бүтэмжтэй байж, буян хишиг хурж, өлзий хутаг орших болтугай.

Зон олон Та бүгд минь сар шинэдээ сайхан шинэлээрэй

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар

2015 оны 2-р сарын 26-ний өдрийн хурлаар

- ◆ Аймгийн ИТХ-ийн 6 дахь удаагийн сонгуулийн 9-р хуралдааны төв зарлах тухай.
- ◆ Увс аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Түргэн, Тариалан, Сагил, Давст, Малчин, Завхан сум байгуулагдсаны 90 жилийн ой, Хяргас сумын дунд сургууль байгуулагдсаны 90 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай
- ◆ Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогыг орон нутагт хэрэгжүүлж буй батлан хамгаалах арга хэмжээнд холбогдох журмын хэрэгжилтийг хангах тухай



- ◆ "Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай
- ◆ Орон нутгийн өмч хөрөнгийг актлах, дуудлага худалдаагаар

худалдах, данс бүртгэлд бүртгэх тухай

- ◆ Зарим иргэдийг төрийн дээд одон, медальд тодорхойлох тухай асуудлыг хэлэлцэн баталлаа.

Улсын Сайн Малчин, Тэргүүний Тариаланч, Фермерүүд Тодорлоо

Мал аж ахуй, газар тариалангийн салбарт гарсан ажлын үр дүнг харгалзан 2015 онд 70 малчныг "Улсын сайн малчин"-аар, таван фермерыг "Улсын тэргүүний фермер"-ээр, 21 иргэнийг "Улсын



тэргүүний тариаланч"-аар, 12 аж ахуйн нэгж байгууллагыг "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-оор тус тус шалгарууллаа.

Увс аймгаас Наранбулаг сумын Хужирт багийн малчин Санжийн Гомбо, Сагил сумын Өндөрмод багийн малчин Норжингийн Баттөмөр, Тэс сумын Баян-Овоо багийн малчин Баатарын Галсанжамц нар шалгарсан байна. Улсын тэргүүний тариаланчаар Улаангом сумын тариаланч Г.Даваа, Тариалан сумын тариаланч Г.Самбуу нар тус тус шалгарчээ.

Төрийн дээд одон медаль гардууллаа

17-р жарны ХҮСЛИЙН ТЭНГЭР хэмээгч модон хонин жилийн сар ишний босгон дээр Увс аймгийн боловсрол, эрүүл мэнд, спорт, эрчим хүч, үйлдвэр үйлчилгээний салбар, төрийн болон төрийн бус



байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж аймгийн хөгжил цэцэглэлтэнд үнэтэй хувь нэмэр оруулж буй нэр бүхий иргэдийг Монгол Улсын төрийн одон медалиар мөн 2014 онд иргэдэд үзүүлсэн ажил үйлчилгээгээрээ бусдыгаа тэргүүлсэн байгууллагуудыг аймгийн ИТХ-ын Дарга Ч.Чимэд, аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ЗДТГ-ын дарга, удирдлагууд салбар салбарын сайчууддаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс шагналыг нь гардуулж, баяр хүргэлээ

"ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ БА ИРГЭНИЙ ЖУРАМТ ҮҮРЭГ СЭДЭВТ" эсээ бичлэгийн уралдааны дүн гарлаа

Монгол улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Гэмт хэргээс урьдчидан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөл,



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Боловсрол, соёлын газар хамтран Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд зохион байгуулсан "Шинэ үндсэн хууль ба иргэний журамт үүрэг" сэдэвт эсээний уралдаанд

амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Уг уралдаанд Улаангом сумын сургуулиудаас гадна хөдөө орон нутгийн сургуулийн сурагчдаас эсэ ирүүлсэн бөгөөд үүнээс

1. I байрыг Улаангом сумын ахлах 3 дугаар сургуулийн 12-А ангийн сурагч Т.Бадамцэцэг
2. II байрыг Баруунтуруун сумын ахлах сургуулийн 11-Б ангийн сурагч Ц.Бат-Өргөө
3. III байрыг Зүүнговь сумын ахлах сургуулийн 12-А ангийн сурагч Б.Цэндмаа
4. Тусгай байрыг Улаангом сумын Цогцолбор 1 дүгээр сургуулийн сурагч Б.Хонгорзул, Улангом сумын ахлах 3 дугаар сургуулийн 10-А ангийн сурагч Д.Ариунзаяа нар шагналт байранд шалгарлаа.

Увс аймгийн сайн малчид тодорлоо

17-р жарны ХҮСЛИЙН ТЭНГЭР хэмээгч модон хонин жилийн сар ишний босгон дээр Увс аймаг сайн малчаа тодрууллаа. Үүнд:



Баруунтуруун сум Баян айраг багийн малчин С.Тулга, Бөхмөрөн сум Хар алтат багийн малчин Б. Батсүх, Гурван жигэртэй багийн малчин Г.Даваасүрэн, Давст сум Торхилог багийн малчин Р.Сүхбаатар, Хандгай багийн малчин О.Батхүү, Завхан сум Айраг нуур багийн малчин Б.Бадрах, Хармагт багийн малчин Б.Аюурзана, Зүүнговь сум Суварга багийн малчин Г.Бадамсамбуу, Тохой багийн малчин С.Ганбат, Зүүнхангай сум Баянгол багийн малчин Д.Тогтохбат, Даланбулаг багийн малчин Б.Лхагвабаяр, Малчин сум Баянмандал багийн малчин П. Сүхбаатар, Баянхайрхан багийн малчин Б. Батхүү, Наранбулаг сум Улаан-Үзүүр багийн малчин Б.Ууганбаяр, Алдар багийн малчин Ч.Лхагважав,



Хужирт багийн малчин Н.Магсаржав, Өлгий сум Өлгий нуур багийн малчин Х.Баасанжав, Хулстнуур багийн малчин Ц.Лхагва, Өмнөговь сум Холбоо багийн малчин Р.Сүхтулга, Холбоо багийн малчин Ц.Мягмардорж, Өндөрхангай Цагааннуур багийн малчин Г.Лхагвасүрэн, Т.Цэрэнтогтох, Саял Өндөрмод багийн малчин Б.Мягмаржав, Үүрэг нуур багийн малчин Г. Ууганбаяр, Тариалан Тарвагатай багийн малчин Ч.Довчин, Тарвагатай багийн малчин Ш.Цэдэнэ, Түргэн Баянхайрхан багийн малчин Г.Пунсанцогвоо, Рашиант багийн малчин Т.Батсүх, Тэс Ханжид багийн малчин Н.Дамжин, Нуур багийн малчин П.Баяраа, Суварга багийн малчин П.Сумъяа, Ховд сум Халиунбулаг багийн малчин Б.Түмэнжаргал, Халиунбулаг багийн малчин Д.Эрдэнэбаяр, Хяргас Бугат багийн малчин Ц.Отгон, Бугат багийн малчин М.Даваасамбуу, Цагаанхайрхан Хунт багийн малчин Ц.Батчулуун, Даланхуруу багийн малчин Я.Аюуш, Улаангом 9-р багийн малчин Ц.Хүлтээ, 2-р багийн малчин Ц.Пүрэвжав нарын нийт 39 хүн аймгийн сайн малчнаар тодорлоо

Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд Улаангом политекник коллежийн удирдах ажилтнуудтай уулзаж ярилцлаа

2015 оны 02 сарын 12-нд Увс аймгийн



Улаангом коллежийн удирдах ажилтнуудын уулзалт ярилцлага боллоо. Уулзалтаар удирдах зөвлөлөөс гарсан тогтоолын хэрэгжилт болон зохион байгуулалт хяналт, багш ажилтнуудын хөгжил, аймгийн түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуудан удирдах зөвлөл болон Улаангом коллежийн ажилтнууд, суралцагчдын зүгээс хийх ажлын талаар санал солилцсан үр дүнтэй уулзалт боллоо.

Улаангом сум:

Улаангом сум 02/07- 02/14-ний хооронд багийн хурлуудаа хийлээ. Хурлаар:

- Улаангом сумын мэдээтэл /2015 онд хийгдэх



ажил/

- Аймгийн 90 жилийн ойг угтсан 108 бүтээлч ажлын жагсаалт
- “Миний гэрээс манай хотын хөгжил эхлэнэ” аяны удирдамж /ой угтсан болзолт уралдаан/
- Аймгийн 90 жилийн ойд иргэдийн оролцоо - /Багийн Засаг дарга нар /
- Багуудад иргэний зөвлөл байгуулах - /Багийн ИНХ-ын дарга/ /нийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх/ зэрэг асуудлуудыг хэлэлцлээ. Хурлыг 13 газар зохион байгуулж, давхардаагүй тоогоор 929 хүн оролцож 154 бүтээлч санал гаргалаа. Багийн хуралд иргэдийн идэвхи оролцоо нэмэгдэж байгаа ч төрийн албан хаагчдын оролцоо хангалтгүй байсаар байна.

Баруунтуруун сум:

1. 2015.02.05-нд сумын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн тэргүүлэгч гишүүдийн зөвлөгөөн, хэлэлцүүлэг боллоо. Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгчид нь (21 гишүүнтэй) сумын иргэний танхимд ээлжит хурлаараа “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн: 2015 оны ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн баталлаа. Үг



хэлэлцүүлгийн үеэр энэ жилийн ажлын зорилго нь сумын эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхи, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэн ажиллахаар боллоо.

2. 2015.02.19 ерөнхий боловсролын бүрэн дунд



сургуулийн сурагчдыг байгальд хайртай, түүнийг хайрлан хамгаалах сэтгэлгээ болон байгальд ээлтэй иргэн төлөвшил зорилгоор “Байгалаа хайрлан хамгаалахад бидний оролцоо” сургалтыг зохион байгууллаа.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210тoot Утас :70453627

Утас :70452517

Утас :70452828

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

uvs.khural.mn

Facebook:

www.facebook.com/groups/uvsi.ith